



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа  
эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан хоёр аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан нэг иргэний дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сод Трейд ХХК-ийн "Сод" зочид буудлын 13/51, Элкс Трейд ХХК "Элкс" дэн буудлын 13/126, Металл Сервис ХХК ХХК-ийн "Их Наяд" дэн буудлын 13/13 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

6. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2016 оны 07 сарын 08 өдрийн  
А/74 дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2016.07.08

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Оноосон нэр     | Байршил                                                |
|-----|-----------------------------|-----------------|--------------------------------------------------------|
| 1   | Боржигоны Бичээч ХХК        | Кинг-2          | Баянзүрх дүүрэг, 8 хороо, 11-276 тоот                  |
| 2   | Сод Трейд ХХК               | Сод             | Баянгол дүүрэг, 5 хороо, Энх тайваны өргөн чөлөө 46/12 |
| 3   | Сумо бургер ХХК             | Спорт цогцолбор | СБД 8 хороо бага тойруу, Спорт цогцолборын байр        |

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2016 оны 07 сарын 08 өдрийн  
А/74 дугаар тушаалын хоёрдугаар  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2016.07.08

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Оноосон нэр | Байршил                                          |
|-----|-----------------------------|-------------|--------------------------------------------------|
| 1   | Металл Сервис ХХК           | Их Наяд     | Баянзүрх дүүрэг, 7-р хороо, 36а                  |
| 2   | Элкс Трейд ХХК              | Элкс        | Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө |

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2016 оны 07 сарын 08 өдрийн  
А/74 дугаар тушаалын гуравдугаар  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ ИРГЭНИЙ  
ЖАГСААЛТ

2016.07.08

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Оноосон нэр | Байршил                                             |
|-----|-----------------------------|-------------|-----------------------------------------------------|
| 1   | Иргэн Ц.Чинзоригт           | Хан Хөхий   | Баянзүрх дүүрэг, 27-р хороо,<br>Дунд Дарь эхийн 5-д |

-ooOoo-